

**НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая. төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">Стратеги төлөвлөгөөний зорилго: Төрийн үйлчилгээг мэргэшсэн, чадварлаг хамт олноор стандартын дагуу хүргэж ажиллах. НТЗАБ УТҮГ-ын СТ-6</p>							
<p align="center">Нэг. Төрийн үйлчилгээг, мэргэшсэн, ёс зүй, сахилга баттай албан хаагчдаар бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах. НТЗАБ УТҮГ-ын СТ-6.1</p>							
1.1	Жолооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх	-	Мэргэшсэн жолоочийн тоо	37	48	<p>Үйлчилгээний жолооч О.Сумъяа(№78284), Я.Цэнд-Аюуш(№270931), Э.Аюуш(№83243), Н.Лхагвадорж(№14044), Т.Анхбаяр(№83152), М.Батбилэг(№41382), Б.Ууганбаатар(№46293), Б.Батхуяг(№713682), Н.Дагвасүмбэрэл(№36650) А.Батбилэг(84124), Ж.Чулуунбаатар(23232), А.Баттулга(81120), Д.Цогт-Эрдэнэ(31744) нар мэргэшсэн жолоочийн үнэмлэхээ авсан. 2023 онд нийт 48 мэргэшсэн үйлчилгээний жолоочтой ажиллаж байна.</p>	100%

1.2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	-	Үйл ажиллагааны хувиар	95%	100%	2023 оны Б/15, Б/112 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Ариунболдод, Б/16 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Гантулгад, Б/24 дугаар тушаалаар техникч нярав Х.Нандинцэцэгт, Б/41 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Мэндбаярт, Б/85 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Ууганбаатарт, Б/87 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Батхуягт, Б/96 дугаар тушаалын дагуу үйлчилгээний жолооч О.Чингэсхүүд тус тус буцалтгүй дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн 2023 оны А/08 дугаар тушаалаар Сар шинийн баярыг тохиолдуулан, А/35 дугаар тушаалаар Олон Улсын ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлсэн.	96%
Хоёр.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд: НЗДҮАХ-4.1.4.1, НХТЖҮЧ-4.1.5, НХТ-4.2.17, 4.2.18							
2.1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хянал тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	-	Санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах	100%	100%	“Шилэн дансны тухай хууль”-д заасны дагуу нийт 139 тайлан мэдээг хугацаанд нь бүрэн тайлагнасан.	100%

2.2	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэн байна.	-	Дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс худалдан авалт хийсэн байх	1	2	“Сүү” ХК-тай хамтран сар бүр нормын сүү, тараг авахад 6.7 сая төгрөгөөр хоргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн, “Хаан шаглаа” ХХК-иас тээврийн хэрэгслийн суудлын бүрээс худалдан авахад 7.5 сая төгрөгний зардал гарган ажилласан.	100%
2.3	Хөрсний бохирдлоос хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар иргэдийн экологийн боловсрол дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо	0	2	2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Дэлхийн хөрсний өдөр болон нийслэлийн хөрс хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хөрсний бохирдлоос хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар байгууллагын ажилтан, албан хаагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн Ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дарга, Цагдаагийн хурандаа М.Батсайханд Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Билгүүнтөгс нар “Экологийн боловсрол” сэдвээр сургалт орсон. Мөн ажилчдад экологийн боловсрол дээшлүүлэх мэдээлэл, танилцуулга хийж, явган болон дугуйн аялал зохион байгуулсан. Нийт 25 ажилтан, албан хаагч хамрагдсан.	90%
2.4	Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 4.2.18. "Дэлхийн	20.0 (сая.төг)	Зохион байгуулах арга хэмжээний тоо	0	1	"Дэлхийн хөрсний өдөр болон нийслэлийн хөрс хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан хөрсний бохирдлоос хамгаалах арга хэмжээний хүрээнд үйлчилгээний жолооч О.Чингэсхүүгийн хашаа байшинд “Эко	70%

	хөрсний өдөр болон нийслэлийн хөрс хамгаалах өдөр" арга хэмжээг зохион байгуулна.					Био-00" хийхээр төлөвлөгөө гарган ажилласан боловч газрын байршил, гадна талбайн багтаамж зэргээс хамаарч том оврын машин, техник, тоног төхөөрөмж багтахгүй болсон тул ирэх жилийн 1 дүгээр улиралд хийхээр хойшлогдсон.	
Гурав. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:							
3.1	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн хэм хэмжээний дагуу байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоол Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1 дэх хэсэгт зааснаар ажилд авсан 34, үндсэн ажилтнаар томилсон 12, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн буюу Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1 дэх заалтаар 30, Хөдөлмөрийн тухай хуулийн 137.5 дахь хэсэгт зааснаар эцгийн 10 хоногийн олговортой чөлөө авсан 9, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулсан ганцаарчлан хаалттай сануулсан, үндсэн цалинг 1 сарын хугацаагаар 20 хувь бууруулсан 2, албан тушаал бууруулсан 1, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 9.1 дүгээр зүйлийн 9.1.7.1-т заасан үндэслэлээр ажлаас халсан 9, тэтгэмж олгосон 15, ээлжийн амралтын 19, өөр	90%

						ажилд шилжүүлэн томилсон 10, хувийн чөлөө олгосон 2, бусад 11, Б тушаал тус тус гарсан байна. Боловсон хүчний холбогдолтой 159 тушаал, байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 44 тушаалыг тус тус гаргасан.	
3.2	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 захирамжийн дагуу тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны 03/18 албан бичгийн дагуу Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөө болон холбогдох бусад бодлогын баримт бичиг байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байхаар боловсруулсан тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлж ажиллав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 03/826 албан бичгийн дагуу Байгууллагын дотоодын хяналт шинжилгээ үнэлгээний журам боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст мэдээ хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийн шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлж, санал шүүмжлэлийг тусгаж төрийн үйлчилгээг сайжруулах хүнд суртал чирэгдлийг арилгах арга замыг тодорхойлохоор ирүүлсэн албан бичгийн дагуу дуудлагын тээврийн	100%

						<p>хэрэгслүүдэд төрийн хүртээмжийн судалгааны код байршуулж хэрэглэгч байгууллагуудаар санал аван 7 хоног бүрийн пүрэв гаригт udval.b@ulaanbaatar.mn хаяг руу илгээж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны 03/127 албан бичгийн дагуу төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд нээлттэй ил тод хүргэсэн тайлан мэдээг 7 хоног бүрийн баасан гаригт 21 удаагийн илтгэх хуудсыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Байгууллагын ил тод байдал, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн М.Солонго руу тогтмол илгээсэн болно.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/7403 албан бичгийн дагуу Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, хэлэлцэх оролцохын өмнө тус бүр бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл гаргах ажлын 5 зорилтын хүрээнд тайлан мэдээг бүрэн гаргаж, хүргүүлэн ажилласан.</p>	
3.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт	-	Үйл ажиллагааны	100%	100%	2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ажилтнуудыг болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн зохицуулагч, дэслэгч А.Лхагвадэлгэр, Б.Гантулга нарыг урьж	100%

	хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах.		хэрэгжилтийн хувиар			“Замын хөдөлгөөний дүрэм”-ийн тухай сургалтыг зохион байгуулсан. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн зөвшөөрөл болон түүнийг зүй зохистой ашиглах талаарх мэдээллийг ажилтнуудад өгсөн. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Донтох эмгэгийн сэтгэл засалч Н.Буянхишиг “Цахим орчин, цахим тоглоомын донтолт, сөрөг нөлөөллийн талаар” нийт ажилтан, албан хаагчдад сургалт явуулсан. Энэхүү сургалтаар гарч болзошгүй эрүүл мэндийн болон эд хөрөнгийн хохирлоос урьдчилан сэргийлэх, цахим орчны хор хөнөөлийн талаарх тодорхой ойлголтыг ажилчид авсан. Уг сургалтанд нийт 85 ажилтан, албан хаагч хамрагдсан.	
3.4	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллах.	Байгууллагын төсөв 7.05 (сая.төг)	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	“Харилцан хүндэтгэе” Жендэрийн үндэсний хорооноос санаачлан Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр зохион явуулсан аянд нэгдсэн. Аяны хүрээнд ажилчдын хүүхдүүдийн дунд Эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулж, шилдгүүдийг тодруулсан. Ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Сөүл Сонгдо” эмнэлэгтэй гэрээ хийж 2023 оны 12 дугаар сарын 20-ноос 2024 оны 01 дүгээр сарын 30-ны хооронд нийт ажилтан, албан хаагчдаа “Сөүл Сонгдо”	90%

						эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулан ажиллаж байна.	
3.5	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн чиг үүргийн дагуу 05 дугаар 13-ны өдөр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Айцын аманд 2022 онд тарьсан 120 модоо тордон, нөхөн сэргээлт хийж, 5 мод шинээр суулгасан. 2023 оны 10 дугаар сарын 14-ний өдөр суулгасан модоо усалж, арчилгаа тордолгоо хийсэн.	100%
3.6	Байгууллагын 50 жилийн ойн хүрээнд ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2023 хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Байгууллагын төсөв 100.0 (сая.төг)	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын 50 жилийн ойг угтан 01 дүгээр сарын 29-ний өдөр “Мөнгөн өвөл 2023” цасны баярын арга хэмжээг зохион байгуулсан. Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 7 хоногийн Бямба гариг бүр НЗДТГ-ын спорт зааланд албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чөлөөт зөв боловсон өнгөрүүлдэг. Мөн байгууллагын фитнесийн өрөөг шинээр тохижуулж албан хаагчдыг чөлөөт цагаараа дасгал хөдөлгөөн хийх нөхцөлөөр хангасан. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын 160 гаруй хүүхдийг хүлээн авч “Хүүхдийн ертөнц” үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Улаанбаатар марафон-2023 Олон Улсын гүйлтийн тэмцээнд байгууллагаа төлөөлж	100%

					<p>оролцсон нийт 8 ажилтан оролцсон бөгөөд тамирчдыг хувцас, өмсгөлөөр хангаж өгсөн.</p> <p>Монгол Улсад Авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 98, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтан “Авто тээвэрчдийн өдөр” 2023 арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>2023-2024 оны хичээлийн шинэ жилийг тохиолдуулан Хүний нөөцийн ажилтан Б.Эрдэнэхишиг, Диспетчер-механик Т.Болортуяа, Ч.Энхбат, Үйлчилгээний жолооч Г.Өлзийсайхан, А.Батзаяа, Э.Энх-Амар, Г.Гансоронзон, Ц.Нэргүй нарын нэгдүгээр ангид шинээр элсэн суралцаж байгаа хүүхдүүдэд хичээлийн хэрэглэл гардуулж, сурлагын өндөр амжилт хүссэн.</p> <p>Байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд энгийн галлагаатай байшинд амьдардаг үйлчилгээний ажилтан Б.Балжинням, Н.Даваажав, үйлчилгээний жолооч С.Баатарсүх, О.Сумъяа, Л.Ганбат, Г.Жаргалсайхан, сантехникч Ц.Батсайхан, манаач Ж.Санжаа, Д.Буяннэмэх, Н.Нямаа нарт 2023 оны Б/126 дугаар тушаалаар түлшний туслалцаа үзүүлсэн.</p> <p>Байгууллагын албан хаагчдын дунд байгууллагын аварга шалгаруулах зургаан төрөлт спорт тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, спортын шилдгүүдээ тодруулсан.</p>	
--	--	--	--	--	---	--

Дөрөв. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

4.1	<p>Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.1. Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчлэх.</p>	-	Парк ашиглалтын хувиар	2022 парк ашиглалтын дундаж коэффициент 90.2	93%	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2008 оны 409, 2022 оны А/789 дүгээр захирамжийн дагуу “Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ”-г 10 байгууллагатай шинэчлэн, 1 байгууллагатай шинээр байгуулав.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Чингэлтэй Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2. “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл” 3. Нийслэлийн Өмчит Улаанбаатар зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК 4. Улаанбаатар Зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах Хороо 5. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар 6. Нийслэлийн Соёл урлагийн газар 7. Улаанбаатар Шинэ бүтээн байгуулалт ХХК 8. Сүхбаатар Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 9. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 10. Нийслэлийн Нийтийн тээврийн газар 	100%
-----	--	---	------------------------	--	-----	--	------

						11.Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл 2023 оны парк ашиглалтын дундаж коэффициент 93.3% болон өссөн.	
4.2	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.2. Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн болон Төрийн үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт, норм, нормативыг мөрдөх, соёлч боловсон, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх.	-	Хэрэглэгчийн зүгээс гомдолгүй байх.	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, жолооч нарын үйлчилгээний соёлыг сайжруулсан. 100%	100%	Үйлчилгээний жолоочийн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахаар 14 тээврийн хэрэгсэлд эмийн сан, 10 тээврийн хэрэгсэлд ослын тэмдэг, 22 тээврийн хэрэгсэлд шалавч резин, 4 тээврийн хэрэгсэлд суудлын бүрээс, 6 тээврийн хэрэгсэлд домакрат, дорцов шинээр авч өгөн иж бүрдлийг бүрдүүллээ. Тээврийн хэрэгслийн стандарт, аюулгүй байдлыг хангах хүрээнд 11 тээврийн хэрэгслийг кузов засварт оруулсан. Мөн 4 дүгээр улиралд тээврийн хэрэгсэлд үйлчилгээний шаардлага, аюулгүй байдлыг хангах хүрээнд 20 тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийхээс гадна хөдөө орон нутагт дуудлагаар үйлчилдэг тээврийн хэрэгслүүдэд багажны шалавч, ком шалавч резин авч өгөн тээврийн хэрэгслийн үзэмжийг сайжрууллаа. Мөн 29 тээврийн хэрэгсэлд өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган өвлийн дугуй шинээр худалдан авч тавилаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4, 2022 оны Засгийн газрын 204 дүгээр тогтоолын дагуу байгууллагын тээврийн хэрэгслүүдийн 95%-ийг тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгосон.	100%
4.3	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын	Нийслэлийн төсөв	Төсөв санхүүгийн үйл	100%	100%	Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон	100%

	дүрмийн 4.3. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргах.	1,409.0 (сая.төг)	ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэмнэлттэй зарцуулах, өглөг авлагагүй ажиллах.			ажилладаг. 2023 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын хугацаанд Нийслэлийн төсвөөс нийт 1,736.3 (сая) төгрөгийн цалингийн санхүүжилтийн гүйцэтгэлтэй байна. Санхүү бүртгэлтэй холбоотой нийгмийн даатгалын тайлан, татварын тайлан, санхүүгийн тайланг цаг тухайд нь холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.	
4.4	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.4. Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, жолооч нарын	-	Сургалт зохион байгуулах тоо	2	6	Байгууллагын албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах 2023-2024 онд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн хүрээнд 2023 онд нийт 10 сургалтыг зохион байгуулсан. Үүнд: 1.НЗДТГ-ын дэргэдэх Хүний нөөцийн хөгжлийн төвөөс "Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, имиж бүрдүүлэлт" сэдэвт сургалтад сэтгэл судлаач, хүмүүнлэгийн ухааны магистр Т.Аззаяагийн удирдлага дор байгууллагын захиргаа, аж ахуйн ажилтнууд диспетчер механикууд 4 цагийн хичээлд суусан.	100%

	<p>боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар ажил зохиох.</p>					<p>2.Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн талаарх ойлголт, төрийн албан хаагчийн зүй зохистой хувцаслалт, биеэ авч явах соёлын талаар сэтгэл судлаачтай ярилцаж харилцан суралцсан.</p> <p>3.“Замын хөдөлгөөний дүрмийн тухай” сургалтыг Сүхбаатар дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Цахим тоглоомын донтолын сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй тус тус хамтран зохион байгуулсан.</p> <p>4.НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 2023.09.13-ны өдөр зохион байгуулсан "Стресс менежмент" сургалтад байгууллагын нийт 8 ажилтан. албан хаагчид сургалтанд хамрагдсан.</p> <p>5.Нийслэлийн Иргэдийн хэрэглээний боловсролын төв НЭМҮТ-н харьяа байгууллагаас 2023.09.25-ны өдөр "Эрүүл мэнд, зөв хооллолтын дадал"-ын талаар сургалтад 20 албан хаагчийг хамруулсан.</p> <p>6. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2023.09.28-29-ний өдрүүдэд зохион байгуулсан Нярав эд хариуцагчдад зориулсан сургалтанд байгууллагын Техникч нярав Х.Нандинцэцэг хамрагдаж, мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн.</p> <p>7. 2023.10.21-ний өдөр Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг, стратеги төлөвлөгөө боловсронгуй</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>болгох вакуумжсан семинарт газрын дарга, захиргааны 4 албан хаагч оролцсон.</p> <p>8.2023.11.28-ны өдөр Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Билгүүнтөгс “Экологийн боловсрол” сэдвээр сургалт орсон. Тус сургалтад захиргаа, аж ахуйн ажилчид, дугаарын хязгаарлалтай нийт 20 албан хаагчдыг хамруулсан.</p> <p>9.ЗХНХД М.Болормаа, МТАБХА Ц.Дэлгэрмаа нар “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам, аргачлал” сэдэвт сургалтад хамрагдсан.</p> <p>10.2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад ТЗХ-ийн дарга, Ерөнхий инженер Ч.Энхсайхан, СТХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч Б.Үүрцайх, ЗХНХ-ийн дарга М.Болормаа нарыг хамруулж, АЗ сертификат авсан.</p>	
4.5	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.5. Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг	-	Арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	100%	<p>2023 онд нийт 14 үйлчилгээний жолооч шинээр болон хугацаа дууссан мэргэшсэн зэргийн үнэмлэхээ авсан.</p> <p>Үйлчилгээний жолооч нарын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор гурван паркад даралтын аппарат, тандагч багажуудыг авч өгөн өдөр бүр ашиглаж байна.</p> <p>Тээврийн хэрэгсэлд гэмтэл учруулсан үйлчилгээний жолооч Б.Мэндбаяраар</p>	100%

	илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах, мэргэшүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах.					<p>үнэлгээний газраас гарсан төлбөрийг бүрэн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгосон.</p> <p>Мөн үйлчилгээний жолооч Ү.Бат-Эрдэнэ өөрийн буруутай үйлдлээс тээврийн хэрэгслийг сэвтүүлснийг илрүүлж хохирлыг төлүүлсэн. 2 жолоочид цаашид алдаа зөрчилгүй ажиллахыг ганцаарчлан сануулж анхааруулсан. Үйлчилгээний жолооч Э.Гэндэндорж өөрийн хариуцаж авсан тээврийн хэрэгсэлд анхаарал болгоомжгүй хандсанаас байгууллагад хохирол учруулсан тул ганцаарчлан сануулж ур чадварын 25%-ийг хасаж арга хэмжээ авлаа. Цаашид анхаарал болгоомжтой ажиллахыг анхааруулсан.</p>	
4.6	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.6. Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0%	100%	<p>Манай байгууллага дуудлагын автомашины үйлчилгээндээ Нийслэлийн Засаг даргын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 409 дүгээр захирамжаар баталсан тарифыг одоог хүртэл мөрдөн ажиллаж байна. Тухайн тарифыг батлах үеийн зах зээлд дээрх шатахууны үнэ өнөөдрийн үнэтэй харьцуулан үзэхэд АИ92 бензин 51%, Дизель түлш 100.5%-иар тус тус нэмэгдсэн байна. Шатах тослох материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой үйлчилгээний тарифыг одоогийн мөрдөж буй тарифаас нэмэгдүүлэн өгөх албан хүсэлтийг 2023.11.16-ны өдөр Нийслэлийн засаг даргын тамгын газрын, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан.</p>	80%

	хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлэн, мөрдөж ажиллах.					Одоогийн байдлаар эцсийн шийдвэр гараагүй болно.	
Тав.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
5.1	Техникийн улсын үзлэг оношилгоо, даатгал хамруулж, засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх.	Орон нутгийн төсөв 111.4 (сая.төг)	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	2023 оны байдлаар тээврийн хэрэгслүүдийн техникийн үзлэг оношилгоонд хамруулахад 2.2 сая төгрөг, даатгал 9.8 сая төгрөгийг зарцуулан ажилласан.	100%
5.2	Тээврийн хэрэгслүүдийн татвар, хураамжийг хуулийн хугацаанд төлж барагдуулах.	Орон нутгийн төсөв 13.9 (сая.төг)	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын эзэмшлийн нийт тээврийн хэрэгслүүдийн албан журмын татвар хураамжинд 8.6(сая) төгрөгийг зарцуулан ажилласан болно.	100%
5.3	“UB.ERP” системийн дуудлагын авто машин захиалах цахим системийг бүрэн нэвтрүүлэх.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	10%	100%	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/789 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн дотоод удирдлагын систем UB ERP системд Дуудлагын автомашин захиалгын системийг шинээр нэвтрүүлсэн. 2023.01.01-ний өдрөөс 2023.12.10-ны өдрийг хүртэл нийтдээ 1117 захиалга авсан үүнээс системээр 936 захиалга, утсаар 181 захиалга авч 991 захиалгыг	100%

						хүлээн авч ажил үйлчилгээнд гаргасан байна. Захиалагч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 126 захиалга цуцлагдсан байна.	
5.4	Дотоод удирдлагын “UB.ERP” системийн Edoc, Өргөдөл гомдлын системүүдийн ашиглалтыг бүрэн хариуцах, хяналт тавьж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	2023 онд байгууллагын хэмжээнд нийт 237 албан бичиг ирсэн. Үүнээс Захиргаа хүний нөөцийн хэлтэст 126, Санхүү төлөвлөлтийн хэлтэст 30, Тээвэр зохицуулалтын хэлтэст 80 албан бичиг ирсэн байна.	100%
5.5	Байгууллагын архивыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүрдүүлж ажиллах.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын архивт 2023 онд нийт 120 баримтыг нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан. Цахим нөхөн бүрдүүлэлтийн хувьд https://arch.ulaanbaatar.mn/ системд 2022 онд үүссэн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 38, боловсон хүчний чиглэлээр 208 захирамжлалын баримтын агуулга тодорхойлон шивж оруулсан.	100%
5.6	Байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлүүлж, зөрчилгүй ажиллах, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах		Хэрэгжилтийн хувь	100%	100%	2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 126 өргөдөл хүсэлт ирснийг программд бүртгэн, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнд: 1. Хүсэлт-126 ✓ Байгууллагын албан хаагчид-94 ✓ Иргэд-32 2. Гомдол-0 ирсэн байна. 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол,	100%

					<p>санал хүсэлтийг Захиргаа хүний нөөцийн хэлтэс 103, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 21, тээвэр зохицуулалтын хэлтэс 2, байгууллагын хэмжээнд нийт 126 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 126 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна. 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар хандалтаараа тэргүүлж байгаа 3 асуудал нь ажилд орох хүсэлт 33 (26.40%), нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай 32 (25.60%), ажлаас чөлөөлөгдөх тухай 23 (18,40%) ирсэн байна.</p> <p>Өргөдөл, гомдлын программд нийт 126 өргөдлийг бүртгэж, 126 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 90 (71,43%), 10 хоногт 18 (14,29%), 15 хоногт 3 (2,38%), 30 хоногт 13 (10,32%). 2023 оны 3 дугаар улирлын байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.</p> <p>Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэж, удирдлагад өдөрт багтаан шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөр нь хүлээн авч танилцан, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хийж ажилласан. 2023 оны байдлаар өдөрт нь багтаан аваагүй зөрчил 113, хугацаа</p>
--	--	--	--	--	--

						хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна.	
Биелэлтийн дундаж хувь							96,5%

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ**
(албан тушаал)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

.....
(гарын үсэг)

/Х.НЯМБААТАР/
(нэр)

Тамга

.....
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:

**НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ УТҮГ-ЫН ДАРГА**
(албан тушаал)



.....
(гарын үсэг)

/Э.БОЛОР-ЭРДЭНЭ/
(нэр)

Тамга

.....
(огноо)